



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/101

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 23 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 06 дугаар хавсралт, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.7 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Удирдлагын академийн сургалтын хөтөлбөр, агуулгын дагуу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтэй" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан багийн Засаг дарга нарыг чадавжуулах "Иргэн төвтэй хөгжлийн төлөө" сэдэвт богино хугацааны сургалтын зардалд 19,571,500 (арван есөн сая таван зуун далан нэгэн мянга таван зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж төрийн байгууллагын ил тод байдлыг хангах "Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтэй" арга хэмжээг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 02-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Арга хэмжээ	Тоо, ширхэг	Мөнгөн дүн
1	Удирдлагын академын сургалтын шууд зардал	*	5217000
2	Өдрийн хоолны зардал	62	6820000
3	Цайны завсарлага	220	4032000
4	Заалны төлбөр	3	900000
5	Багш нарын буудлын зардал	12	1750500
	Сургагч багшийн томилолтын зардал	6	852000
			19571500